



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

# ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

Дугаар 2016/12

Улаанбаатар хот  
2017 он

**ГАРЧИГ**

Агуулга	Хуудасны дугаар
1. Мал аж ахуй	2
2. Газар тариалан	6
3. Зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	8
4. Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ	9

Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээг ашиглав.

---


ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

## 1. МАЛ АЖ АХУЙ

Улсын хэмжээгээр 2016 оны эцэст 61549.2 мянган толгой мал, үүнээс 3635.5 мянган адуу, 4080.9 мянган үхэр, 401.3 мянган тэмээ, 27856.6 мянган хонь, 25574.9 мянган ямаа тоологдов.


Малын нийт тоо өмнөх оноос 5569.5 мянга (9.9%), адуу 340.2 мянга (10.3%), үхэр 300.5 мянга (7.9%), тэмээ 33.4 мянга (9.1%), хонь 2913.5 мянга (11.7%), ямаа 1981.9 мянга (8.4%)-аар өслөө.

*Малын тоо, төрлөөр, сая толгой, жил бүрийн эцэст*



Нийт мал сүрэгт 2016 онд хонь 45.3 хувь, ямаа 41.6 хувь, үхэр 6.6 хувь, адуу 5.9 хувь, тэмээ 0.7 хувийг эзэлж, өмнөх оноос хонины эзлэх хувь 0.7 пунктээр өсч, үхрийнх 0.1 пунктээр, ямааных 0.6 пунктээр буурч, адуу, тэмээнийх өмнөх оны түвшинд байна.


*Нийт сүрэгт 5 хошуу малын эзлэх хувь, жил бүрийн эцэст*



Малын тоо 2016 оны эцэст өмнөх оноос 18 аймаг, Улаанбаатар хотод 5 төрлөөр өсчээ. Өвөрхангай (697.6 мянга), Хөвсгөл (691.3 мянга), Говь-Алтай (574.9 мянга), Архангай (552.6 мянга), Баянхонгор (464.5 мянга) аймагт малын тоо хамгийн их өсчээ. Өвөрхангай (5208.6 мянга), Хөвсгөл (5089.4 мянга), Архангай (5009.6 мянга), Төв (4705.9 мянга), Баянхонгор (4236.3 мянга) аймаг 2016 онд хамгийн олон мал тоолуулж, малын тоогоор тэргүүлж байна.

Адуун сүргийн тоогоор Төв, Архангай, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар аймаг; үхэр сүргийн тоогоор Архангай, Хөвсгөл, Төв, Хэнтий, Булган аймаг; тэмээн сүргийн тоогоор Өмнөговь, Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Дундговь аймаг; хонин сүргийн тоогоор Архангай, Хөвсгөл, Төв, Өвөрхангай, Хэнтий аймаг; ямаан сүргийн тоогоор Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Хөвсгөл, Ховд аймаг тэргүүлж байна.

Малын тоо, аймаг, нийслэлээр, 2016 оны эцэст, мянган толгой




Малтай өрхийн тоо 2016 оны эцэст улсын хэмжээгээр 223.8 мянга болж, 160.7 мянган өрх нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг малчин өрх байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж буй малчид 2016 оны эцэст 311.4 мянга болж, 16-34 насны малчид 34.8 хувь, 35 наснаас тэтгэвэрт гарах хүртэлх насны малчид 55.3 хувь, тэтгэврийн насны малчид 9.9 хувийг эзэлж байна.

Малтай нийт өрхийн тоо өмнөх оноос 3.2 хувиар, 500 хүртэлх малтай өрхийн тоо 1.1 хувиар, 500-аас дээш малтай өрхийн тоо 16.1 хувиар өссөн байна.

Малтай өрхийн тоо, малын тооны бүлгээр, жил бүрийн эцэст, мянган өрх




Улсын хэмжээгээр малтай нэг өрхөд ногдох малын тоо 2016 онд дунджаар 273 болж, өмнөх оноос 16 толгой (6.2%)-гоор өслөө. Малтай нэг өрхөд 16 адуу, 18 үхэр, 2 тэмээ, 124 хонь, 114 ямаа ногдож байна. Өмнөх оноос малтай нэг өрхөд ногдох адуу, үхэр тус бүр 1 толгой, хонь 10 толгой, ямаа 6 толгойгоор өсч, харин тэмээний тоо өөрчлөгдөөгүй байна.

Малтай өрхийн 34.9 хувь нь 100 хүртэл, 20.5 хувь нь 101-200, 28.2 хувь нь 201-500, 11.9 хувь нь 501-999, 4.4 хувь нь 1000-аас дээш тооны малтай байна.

Малтай нэг өрхөд ногдох малын тоо Өвөрхангай, Архангай, Ховд, Баянхонгор, Сүхбаатар, Төв, Өмнөговь, Булган, Дорноговь, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Хэнтий аймагт улсын дунджаас 8-114 толгойгоор их, бусад аймаг, Улаанбаатар хотод 11-192 толгойгоор бага байна.

Малчин нэг өрхөд ногдох малын тоо 2016 оны эцэст дунджаар 341 болж, өмнөх оноос 18 толгой (5.4%)-гоор өслөө. Нийт малчин өрхийн 40.7 хувь нь Хангайн, 25.3 хувь нь Баруун, 21.2 хувь нь Төвийн, 11.8 хувь нь Зүүн бүсэд, 1.1 хувь нь Улаанбаатарт ногдож байна.


Малчин болон малтай нэг өрхөд ногдох мал, жил бүрийн эцэст



Улсын хэмжээнд 2016 онд төллөх насны 23.9 сая хээлтэгч малын 20.5 сая (85.8%) нь төллөжээ. Гүүний 77.4 хувь, үнээний 81.8 хувь, ингэний 51.7 хувь, эм хонины 89.5 хувь, эм ямааны 83.6 хувь нь төллөв. Төллөлтийн хувь өмнөх оноос 3.8 пункт, гүүнийх 6.7 пункт, үнээнийх 5.6 пункт, эм ямааных 5.2 пункт, эм хониных 2.0 пунктээр буурч, ингэнийх 3.3 пунктээр нэмэгдсэн байна.


Нийт гарсан төлийн 19.7 сая (95.9%)-ийг 2016 онд бойжуулсан нь өмнөх оноос 542.2 мянган толгойгоор, харин төл бойжилтын хувь 0.1 пунктээр өссөн байна. Унаганы 96.6 хувь, тугалын 97.2 хувь, ботгоны 98.3 хувь, хурганы 96.6 хувь, ишигний 94.9 хувь нь бойжиж, төл бойжилтын хувь өмнөх оноос тугалынх 0.3 пунктээр буурч, бусад төрөлд 0.1-0.4 пунктээр өссөн байна.

Бойжуулсан төл, жил бүрийн эцэст, мянган толгой



Оны эхэнд тоологдсон нийт малын 2.6 хувь буюу 1452.1 мянган том мал 2016 онд зүй бусаар хорогдов. Оны эхний малд хорогдлын эзлэх хувь Баруун бүсэд 3.3, Зүүн бүсэд 3.0, Төвийн бүсэд 2.6, Хангайн бүсэд 2.0, Улаанбаатар хотод 1.6 байна. Нийт хорогдсон малын 73.8 мянга буюу 5.1 хувь нь өвчнөөр хорогдсон байна.

Хорогдсон мал тоо, жил бүрийн эцэст, мянган толгой




Хонин толгойд шилжүүлснээр хадлан, бэлчээрийн 100 га талбайд ногдох малын тоо 2016 онд 92 толгой болж, өмнөх оноос 9 толгой (10.8%)-гоор өслөө. Энэ үзүүлэлт Орхон аймагт 740, Улаанбаатар хотод 506, Дархан-Уул аймагт 353, Архангай аймагт 262, Булган аймагт 250 толгой болж, улсын дунджаас 158-648 толгойгоор их байна.

## 2. ГАЗАР ТАРИАЛАН


Улсын хэмжээгээр 2016 онд нийт 505.3 мянган га талбайд тариалалт хийснээс 377.8 мянган га-д үр тариа, 15.0 мянган га-д төмс, 9.1 мянган га-д хүнсний ногоо, 29.9 мянган га-д тэжээлийн ургамал, 66.2 мянган га-д техникийн ургамал тариалсан нь өмнөх оноос нийт тариалсан талбай 14.2 мянган га (2.7%) -аар буурсан байна.

Хураасан үр тариа, жил бүрийн эцэст, мянган тонн



Үр тариа 483.5 мянган тонн, төмс 165.3 мянган тонн, хүнсний ногоо 94.4 мянган тонныг 2016 онд хураан авч, 1275.4 мянган тонн хадлан, 45.8 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн байна. Өмнөх оноос үр тариа 267.2 (2.2 дахин) мянган тонн, төмс 1.6 мянган тонн (1.0%) хүнсний ногоо 22.1 (30.5%) мянган тонн, хадлан 246.7 (24.0%) мянган тонн, гар тэжээл 5.9 (14.8%) мянган тонноор өссөн байна.

Хураасан төмс, хүнсний ногоо, жил бүрийн эцэст, мянган тонн



Нэг га-гаас 12.8 центнер үр тариа, 110.1 центнер төмс хураасан нь өмнөх оноос үр тариа 7.3 (2.3 дахин) центнерээр өсч, төмс 17.4 (13.7%) центнерээр буурсан байна. Үр тарианы га-гийн ургац Баян-Өлгий, Төв, Ховд, Завхан, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймагт улсын дунджаас 0.5-11.0 центнерээр бага, харин бусад аймагт 0.3-21.3 центнерээр их байна.


Төмсний га-гийн ургац Орхон, Дархан-Уул, Өвөрхангай, Баянхонгор, Увс, Сэлэнгэ, Ховд аймагт улсын дунджаас 0.6-21.1 центнерээр их, харин Улаанбаатар хот болон бусад аймагт 0.7-73.5 центнерээр бага байна.

Хураасан үр тарианы 50.6 хувь нь Сэлэнгэ, 17.7 хувь нь Төв, 11.1 хувь нь Булган, 4.7 хувь нь Хөвсгөл аймагт, 3.9 хувь нь Дархан-Уул; төмсний 39.1 хувь нь Төв, 25.7 хувь нь Сэлэнгэ, 5.6 хувь нь Ховд, 4.5 хувь нь Дархан-Уул, 3.0 хувь нь Булган аймагт ногдож байна.

Хураасан үр тарианы 72.2 хувь нь Төвийн, 21.0 хувь нь Хангайн, 4.9 хувь нь Зүүн, 1.9 хувь нь Баруун бүсэд ногдож байна. Хураасан үр тарианы хэмжээ өмнөх оноос Баруун бүсэд 4.3 (84.4%) мянган тонн, Хангайн бүсэд 52.6 (7.8%) мянган тонн, Төвийн бүсэд 224.6 (2.8 дахин) мянган тонноор өсч, Зүүн бүсэд 14.3 (37.9%) мянган тонноор буурлаа.

Хураасан нийт хүнсний ногооны 34.6 хувь нь Сэлэнгэ, 15.2 хувь нь Дархан-Уул, 9.6 хувь нь Ховд, 8.5 хувь нь Төв аймагт, 5.8 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

*Бэлтгэсэн хадлан, тэжээл, жил бүрийн эцэст, мянган тонн*



Бэлтгэсэн нийт хадлангийн 211.9 (16.6%) мянган тонн нь Хөвсгөл, 167.6 (13.1%) мянган тонн нь Сэлэнгэ, 125.4 (9.8%) мянган тонн нь Хэнтий, 121.4 (9.5%) мянган тонн нь Төв, 101.8 (8.0%) мянган тонн нь Булган аймагт үлдсэн 547.3 (42.9%) мянган тонн нь Улаанбаатар хот болон бусад аймагт ногдож байна.

## 3.ЗАРИМ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэм. нэгж	2013	2014	2015	2016*
Үхрийн мах	тн	7 373.7	5 496.4	2 859.8	1 556.3
Хонины мах	тн	6 416.6	5 412.7	3 243.5	1 494.8
Адууны мах	тн	2 354.6	2 237.5	3 731.6	4 688.3
Ямааны мах	тн	3 614.1	3 636.7	2 765.6	1 216.8
Өлөн гэдэс	мян.	696.1	407.3	625.6	878.2
Хиаман төрлийн бүтээгдэхүүн	гогцоо				
Шингэн сүү	тн	2 347.1	3 488.2	3 512.6	4 814.0
Тараг	мян.л	26 607.4	28 311.3	27 054.6	29 589.6
Цөцгий, цөцгийн тос	мян.л	8 803.5	7 093.2	7 113.1	7 988.9
Аарц, бяслаг	тн	1 191.8	1 450.5	1 445.4	646.5
Дээд гурил	тн	140.7	106.9	146.6	112.1
Нэгдүгээр гурил	тн	45 789.1	45 217.6	39 946.0	44 514.0
Хоёрдугаар гурил	тн	169 204.0	157 915.6	145 068.2	148 504.9
Талх	тн	31 519.1	25 181.2	21 519.2	16 659.2
Нарийн боов	тн	25 047.4	30 159.4	28 620.4	26 371.1
Бялуу	тн	18 747.3	18 822.5	17 969.2	17 609.2
Чихэр	тн	860.8	1 017.6	1 228.5	1 094.5
Жигнэмэг	тн	44.6	56.4	42.7	37.3
Спирт	тн	489.2	470.5	478.8	491.3
Архи	мян.л	9 950.4	9 126.0	8 668.6	8 647.7
Дарс	мян.л	24 774.0	24 181.4	21 131.9	23 808.1
Шар айраг	мян.л	78.3	76.7	75.0	79.5
Цэвэр ус	мян.л	63 775.3	67 740.7	74 857.2	75 732.4
Амтат ус, ундаа	мян.л	47 360.4	52 119.0	60 550.2	61 213.4
Жүүс	мян.л	78 918.3	92 537.0	112 571.4	128 887.6
Хивс	мян.м <sup>2</sup>	84 426.6	80 178.3	70 329.1	55 779.9
Ноолууран сүлжмэл эдлэл	мян.ш	852.9	743.6	680.1	432.9
Самнасан ноолуур	мян.ш	932.8	954.4	829.3	812.5
Эсгий	тн	521.8	633.2	754.5	782.1
Тэмээний ноосон хөнжил	мян.м	178.2	163.1	164.0	99.9
Эсгий гутал	мян.м	14.7	18.5	23.0	12.2
Нэхий дээл	мян.хос	21.0	10.8	13.0	6.5
Савхин гутал, ботинк	ш	16 771	14 151	10 218	9 217
Барилгын модон хаалга, цонх	мян.хос	26.5	49.3	70.6	44.5
Вакуум цонх, хаалга	м <sup>2</sup>	12 412.3	14 615.9	7 834.6	5 049.6
Зүсмэл материал	м <sup>2</sup>	50 065.7	73 960.4	63 607.8	33 797.4
Дэвтэр	м <sup>3</sup>	9 792.7	16 371.4	15 226.6	10 442.5
Ариун цэврийн цаас	мян.ш	6 552.9	11 448.8	13 665.6	13 774.4
Сонин	мян.ш	5 479.8	2 972.8	2 740.3	1 067.7
Ном	сая.х.д.х	55.9	39.5	36.0	35.4
	сая.х.д.х	55.5	62.5	77.0	53.0



#### 4. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ

Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2016 оны 12 дугаар сард үхрийн 2 метрээс дээш урттай ширний дундаж үнэ Говь-Алтай, Сэлэнгэ, Баянхонгор, Увс, Ховд, Хэнтий аймагт хамгийн бага буюу 20.0-25.0 мянган төгрөг; Булган, Дорнод, Сүхбаатар, Архангай, Дархан-Уул аймагт хамгийн их буюу 35.0-40.0 мянган төгрөг; адууны ширний дундаж үнэ Сэлэнгэ, Хэнтий, Увс, Завхан, Ховд, Орхон, Говьсүмбэр аймаг, Улаанбаатар хотод хамгийн бага буюу 20.0-30.0 мянган төгрөг; Өвөрхангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Хөвсгөл, Дархан-Уул, Сүхбаатар аймагт хамгийн их буюу 38.0-40.0 мянган төгрөг; ямааны 1 килограмм цагаан ноолуурын үнэ Архангай, Сүхбаатар, Орхон, Говь-Алтай аймаг, Улаанбаатар хотод хамгийн бага буюу 40.0-49.0 мянган төгрөг; Баян-Өлгий, Завхан, Ховд, Баянхонгор, Өмнөговь, Өвөрхангай аймагт хамгийн их буюу 50.0-52.0 мянган төгрөг байна.